

Батлав с/м.....Ч.Эрдэнэчимэг.

Булган аймгийн Булган сумын 1-р бүрэн дунд
сургуулийн 3^а ангид *Хүн орчин *хичээл
заах хөтөлбөр

2012-11-16

Ээлжит хичээлийн сэдэв: “Цаг агаар ямар байгааг мэдэцгээ.”

Зорилго: Цаг агаарын байдлыг ажиглуулан тэмдэглэл хөтлүүлэх, амьдрал ахуйдаа зөв зохистой хэрэгжүүлж хэвшүүлэх

Зорилт:

- Цаг агаарын байдлыг өдөр тутам ажиглах , таних тэмдгээр тэмдэглэж сурах
- Цаг агаарын мэдээг сонсох, унших
- Тухайн өдрийн цаг агаарын байдалд тохируулан зөв хувцаслаж сурах
- Цаг агаарын мэдээг долоо хоногоор нэгтгэн дүгнэж ярилцах

Арга зүй: Хичээлийг ажиглалтын арга , тайлбарлан таниулах, турших, харилцан ярилцах аргуудаар хослуулан явуулна. Сурагчдаар ангийн температурыг хэмжүүлж тодорхойлуулна.

Хэрэглэгдэхүүн :

- ✓ Цаг агаарыг ажиглаж, тэмдэглэл хөтлөх хүснэгт
- ✓ Таних тэмдгийн үзүүлэн
- ✓ Тасалгааны термометр

Хичээлийн явц:

Хичээлийн элемент	хугацаа	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа
Сэргэн санах үе	2мин	-Манай ард түмэн газар, усаа хэрхэн хүндэтгэдэг байсан бэ?	-усанд сүү хийхгүй -нүүгээд бууриа цэвэрлэдэг -Голын усны орчим хог хаяхгүй -Овоондоо сүү өргөж, чулуу нэмж Овооны их тандаа Олзны их наддаа гэж хэлээд нар зөв тойрно
Сэдэлжүүлэх үе шаг	3 мин	Цэнхэр залаа аяыг сонсоно. Та нар энэ аяыг сонсож байсан уу? Энэ аялгууны нэрийг мэдэх үү? Цэнхэр залаа гэдэг нэртэй аялгуу болохыг хэлнэ. Багш нь яагаад энэ аяыг сонгож сонсгосон гэж бодож байна? Өнөөдөр бүгдээрээ “Цаг агаар ямар байгааг мэдэцгээ.” Гэсэн хичээл үзье.	-Сонсож байсан. -Телевизорээр сонссон. -Цаг агаарын мэдээ гарахад -мэдэхгүй Цаг агаарын тухай үзэх гэж байгаа..... Гарчиг бичнэ

Шинэ мэдлэг бүтээх	20 мин	-Өглөө та нарыг ирэхэд гадаа ямар байсан бэ? Одоо ангид ямар байна вэ? Дулаан байна гэдгийг яаж мэдэж байна бэ? Ангид дулаан болон хүйтэн байгааг өөр яаж мэдэж болох вэ? Ямар зүйлүүдийн халуун хүйтнийг хэмжиж болох вэ? Термометрийн төрөл ,бүтцийг танилцуулж тэмдэглэх аргыг хэлнэ.\тасалгааны, гаднах температур хэмжигч\ Туршилт -1 Ангийн дулааныг хэмжүүлнэ. Өглөө ирэхэд гадаа ямар байсан билээ? Одоо ямар байгаа бол? Өглөө хүйтэн байснаа одоо яагаад дулаан байна вэ? Орой ямар болох бол? Яагаад ингэж өөрчлөгдөөд байна вэ? Энэ өөрчлөлтийг юу гэж хэлэх вэ? Та нар юу гэж бодож байна вэ? “Агаарын байдал тогтворгүй богино хугацаанд өөрчлөгдөж байдгийг цаг агаар гэнэ.	-нартай -үүлтэй - хүйтэн - цэлмэг -цас бударч байна гэх мэт Дулаахан, халуун -Даарахгүй байна. -Халууцаж байна. Халууны шилээр -Дулаан хэмжигч багаж -Термометр Градус-хэм Термометр – дулаан хэмжигч -тасалгааны -хүний -усны гаднах - цаг агаарын Сурагчид термометрийн заалтыг ажиглаж дэвтэртээ бичнэ. -хүйтэн, сэрүүхэн дулаан -Арай дулаахан - дулаарч байгаа байх, хүйтэн хэвээрээ -өглөө нар байхгүй -дөнгөж нар гарч байсан учраас хүйтэн -өдөр болоход дулаахан болдог -орой нар жаргахад дахин хүйтэн болно. -Цаг агаар,цаг уур - Цаг агаарын мэдээ
	Алжаал тайлах дасгал 2 мин	Ангид ... цэцэг дэлгэрлээ. Салхи гарлаа. Цэцэг найгалаа. Бороо нэг хоёроор дусаллалаа. Бороо ширүүслээ. Бороо нэг хоёроор дуслаа. Бороо зогслоо. Нар гарлаа.	Хүүхдүүд алжаал тайлах дасгалыг багшийг дагаж хийнэ.

		“Цаг агаарыг ажиглацгаая” тэмдэглэл хөтлөх хүснэгт, таних тэмдгийг самбарт байрлуулна. - Таних тэмдгийг тайлбарлаж өгнө. - Хүснэгтийг яаж бөглөх аргачлал өгнө. Өчигдрийн цаг агаарыг хүснэгтэд тэмдэглэнэ.	-Таних тэмдгийг нүдэлж дэвтэртээ зурж тэмдэглэнэ.
Баталгах	8 мин	Таних тэмдгүүдийг ашиглан өнөөдрийн цаг агаарын байдлыг тэмдэглэх даалгавар өгнө. Сурагчдыг даалгавраа гүйцэтгэсний дараа багш самбарт хүснэгт бөглөнө. Цаг агаарыг урьдчилан мэдэж болох уу? Монголчууд цаг агаарыг урьдчилан яаж мэддэг байсан бэ?	Өнөөдөр ямар байгааг сурагч бүр хүснэгтэнд бичиж ,зурж тэмдэглэнэ. -Багшийн бөглөсөн хүснэгтийг ажиглаж буруу зөвөө хянаана. Болно уламжлалт арга, Ус цаг уур,орчны шинжилгээний газар -Тэнгэрийн хаяа улайж нар жаргавал маргааш дулаан болно. -нар сар хүрээлвэл хүйтэн болно.
Нэгтгэн дүгнэх	3 мин	Цаг агаарыг урьдчилан мэдэх нь ямар ач холбогдолтой вэ? Цаг агаарын мэдээг урьдчилан мэдэх нь хүмүүсийн эрүүл мэнд,ажил хөдөлмөр ,аж амьдралд тустай	-хувцсаа тохируулж өмсөнө. -малаа ойр хариулна - ногоо,тариагаа хурдан хурааж авна,хучина -Түлээ түлшээ бэлтгэнэ -Хадлан өвсөө авна. - Цонхоо дулаална.....
Гэрийн даалгавар	2 мин	-Цаг агаарыг ажиглан хөтлөх хүснэгтээ хөтлөөрэй. -Цаг агаарыг урьдчилан мэдэх уламжлалт аргуудаас мэдэж ирээрэй	

Самбар төлөвлөлт

гарчиг

				Сурагчдын хариулт	“Цаг агаарыг ажиглацгаая” тэмдэглэл хөтлөх хүснэгт
	Өглөө	Өдөр	Шөнө		
хэм					
үгээр					
				Салхи Бороо Цас Шуургагэх мэт	
Ангид	Гадаа				

Батлав с/м.....Ч.Эрдэнэчимэг.

Булган аймгийн Булган сумын 1-р бүрэн дунд
сургуулийн 3^а ангид *Хүн орчин *хичээл
заах хөтөлбөр

2012-11-16

Ээлжит хичээлийн сэдэв: “Цаг агаарын тухай мэдэцгээе.”

Зорилго: Цаг агаарын байдлыг ажиглуулан тэмдэглэл хөтлүүлэх,амьдрал ахуйдаа зөв
зохистой хэрэгжүүлж хэвшүүлэх

Зорилт:

- Цаг агаарын байдлыг өдөр тутам ажиглах ,таних тэмдгээр тэмдэглэж сурах
- Цаг агаарын мэдээг сонсох,унших
- Тухайн өдрийн цаг агаарын байдалд тохируулан ажил хөдөлмөрөө зохицуулж сурах

Арга зүй: Хичээлийг ажиглалтын арга ,тайлбарлан таниулах,туриших,харилцан ярилцах
 аргуудаар хослуулан явуулна.

Хэрэглэгдэхүүн :

- ✓ Цаг агаарыг ажиглаж, тэмдэглэл хөтлөх хүснэгт
- ✓ Таних тэмдгийн үзүүлэн
- ✓ Тасалгааны термометр
- ✓ Цаг агаарын мэдээний бичлэг
- ✓ “Цэнхэр залаа” аялгуу

Хичээлийн явц:

Хичээлийн элемент	хугацаа	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа
Сэргээн санах үе	2мин	❖ Манай ард түмэн газар, усаа хэрхэн хүндэтгэдэг байсан бэ?	-усанд сүү хийхгүй -нүүгээд бууриа цэвэрлэдэг -Голын усны орчим хог хаяхгүй -Овоондоо сүү өргөж, чулуу нэмж - --- Овооны их тандаа Олзны их наддаа гэж хэлээд нар зөв тойрно -Сүү цагаа хутгасан шанагаар голын ус хутгадаггүй -Газарт зоосон гадас шонг авч нүхийг нь бөглөдөг -Ламтай овоонд гарч сүү өргөж, ном уншдаг -Мод хугалдаггүй.
Алжлуулх үе	20 сек	❖ Цэнхэр залаа аяыг сонсгоно.	


Шинэ мэдлэг бүтээх	40 сек	❖ Та нар энэ аяыг сонсож байсан уу?	-Сонсож байсан. -Телевизорээр сонссон. -Цаг агаарын мэдээ гарахад -мэдэхгүй -Мэдээний хамгий сүүлд гардаг -Үндэсний телевизээр явдаг			
	2 мин	❖ Энэ ямар нэртэй аялгуу вэ?	- Мэдэхгүй - Цаг агаар - Цэнхэр залаа			
		❖ Цэнхэр залаа гэдэг нэртэй аялгуу болохыг хэлнэ.				
	2 мин	❖ Багш нь яагаад энэ аяыг сонгож сонгосон гэж бодож байна?	Цаг агаарын тухай үзэх гэж байгаа..... Гарчиг бичнэ			
		❖ Өнөөдрийн хичээлийн сэдэв “Цаг агаарын тухай”.				
Шинэ мэдлэг бүтээх	1 мин	❖ Өглөө та нарыг ирэхэд гадаа ямар байсан бэ?	-нартай -үүлтэй - хүйтэн - цэлмэг -цас бударч байна гэх мэт			
		❖ Одоо ангид ямар байна вэ?	Дулаахан, халуун			
		❖ Дулаан байна гэдгийг яаж мэдэж байна бэ?	-Даарахгүй байна. -Халууцаж байна.			
	3 мин	❖ Гадаа ямар байгааг өөрөөр яаж мэдэж болох вэ? ❖ Ангид дулаан болон хүйтэн байгааг өөр яаж мэдэж болох вэ?	-Дулаан хэмжигч багаж -Термометр -Градус-хэм -Термометр – дулаан хэмжигч -цаг агаарын мэдээ -Хиймэл дагуулаас -Тавган антенаас			
	2 мин	❖ Термометрийн төрөл,ашиглах арга аюулгүй ажиллагааны дүрмийг танилцуулж, заалтыг тэмдэглэх аргыг тайлбарлана.\тасалгааны, гаднах температур хэмжигч, градус, хэм,- c ⁰ , +c ⁰ , мөнгөн ус\	- Ажиглана. -Сонсоно.			
	2 мин	Туршилт -1 ❖ Ангийн дулааныг хэмжсэн термометрийн заалтыг ажиглуулна. ❖ Багш самбарт доорхи хүснэгтийн ангид хэсгийг бөглөнө. <table border="1"><tr><td>Ангид</td><td>Гадаа</td></tr><tr><td></td><td></td></tr></table>	Ангид	Гадаа		
Ангид	Гадаа					

	5 мин	Туршилт-2 ❖ Багш сурагчдыг дагуулан гадаа байрлуулсан термометрийн заалтыг ажиглуулахаар ангиас гарна. ❖ Багш сурагчдыг дагуулан орж ирээд ажигласан термометрийн заалтыг самбар дахь хүснэгтийн гадаа гэсэн хэсгийг бөглөнө.	Сурагчид хувцсаа өмсөж багшийг дагаж гарна. - Сурагчид термометрийн заалтыг ажиглаад ангид орж заалтыг дэвтэртээ тэмдэглэнэ.
	3 мин	❖ Хүүхдүүдээ ангид болон гадаа хийсэн туршилтын үр дүнг ажиглаарай. ❖ Нэмэх хасах температурын ялгааг гаргуулна.	❖ Ажиглана. ❖ 0-ээс доош заавал $-c^0$, 0-ээс дээш заавал $+c^0$ байна.
	1 мин	❖ Салхины чимээ, борооны чимээ, аянгатай ширүүн борооны чимээ, цасан шуурганы чимээг сонсоно.	❖ Сонсоно.
	2 мин	❖ За хүүхдүүдээ та нар юуны чимээ сонссон бэ?	❖ Салхи, шуурга, бороо, аянга цахилгаан, цасан шуурганы чимээ
	2 мин	❖ Хүүхдүүдээ саяын сонссон чимээндээ тохируулан хөдөлгөөн хийцгээгээрэй.	❖ Ссссс гэж дуугарч найгах, бороон чимээг тогших гэх мэт.....
	2 мин	❖ Байгалийн энэ хүйтэрч дулаарч байгаа байдал, нартай бүрхэг өдөр, салхи бороо гэх мэт өөрчлөлтийг юу гэж хэлэх вэ? Та нар юу гэж бодож байна вэ?	❖ Цаг агаар, цаг уур, цаг агаарын мэдээ, байгалийн үзэгдэл, гэх мэт
	2 мин	❖ “Агаарын байдал тогтворгүй богино хугацаанд өөрчлөгдөж байдгийг цаг агаар гэнэ.” Хэлж өгч бичүүлнэ.	Сурагчид дэвтэртээ бичнэ.
	2 мин	“Цаг агаарыг ажиглацгаая” тэмдэглэл хөтлөх хүснэгт, таних тэмдгийг самбарт байрлуулна. • Таних тэмдгийг нэг сурагчаар ялгуулж тохирох газарт нь байрлуулна. • Хүснэгтийг яаж бөглөх аргачлал өгнө.	❖ Нэг сурагч самбарт тэмдэг байрлуулна. ❖ Сурагчид таних тэмдгийг нүдэлж хүснэгтэн мэдээлэлд зурж тэмдэглэнэ.
Бататгах	3мин	❖ Таних тэмдгүүдийг ашиглан өнөөдрийн цаг агаарын байдлыг зурж тэмдэглэх даалгавар өгнө. ❖ Сурагчдыг даалгавраа гүйцэтгэсний дараа нэг сурагчаар самбарт хүснэгт бөглүүлнэ.	❖ Өнөөдөр ямар байгааг сурагч бүр хүснэгтэнд бичиж, зурж тэмдэглэнэ. ❖ Бөглөсөн хүснэгтийг ажиглаж, сурагчид буруу зөвөө хянана.

	2 мин	❖ Монголчууд цаг агаарыг урьдчилан яаж мэддэг байсан бэ?	❖ Тэнгэрийн хаяа улайж нар жаргавал маргааш дулаан болно. ❖ Нар сар хүрээлвэл хүйтэн болно. ❖ Нохой цагариглаж хэвтвэл хүйтэн болно. ❖ Хонь хотноосоо гараад хэвтээд байвал цас орно. ❖ Нар улаанаараа жаргавал шөнөдөө хүйтэн хононо.
Нэгтгэн дүгнэх	2 мин	❖ Цаг агаарыг урьдчилан мэдэх нь ямар ач холбогдолтой вэ? ❖ Багш чиглүүлэх асуулт асууна. ❖ Цаг агаарын мэдээг урьдчилан мэдэх нь хүмүүсийн эрүүл мэнд,ажил хөдөлмөр ,аж амьдралд тустай	-хувцсаа тохируулж өмсөнө. -малаа ойр хариулна - ногоо,тариагаа хурдан хурааж авна,хучина -Түлээ түлшээ бэлтгэнэ -Хадлан өвсөө авна. - Цонхоо дулаална.....
Гэрийн даалгавар	1 мин	❖ Цаг агаарыг ажиглан хөтлөх хүснэгтээ үргэлжлүүлэн хөтлөөрэй. ❖ Цаг агаарыг урьдчилан мэдэх уламжлалт аргуудаас мэдэж ирээрэй	Сурагчид даалгавраа тэмдэглэж авна.

Самбар төлөвлөлт

гарчиг

<table border="1"> <tr> <td>Ангид</td> <td>Гадаа</td> </tr> <tr> <td></td> <td></td> </tr> </table> Градус Температур Термометр Хэм	Ангид	Гадаа			Сурагчдын хариулт Салхи Бороо Цас Шуургагэх мэт	“Цаг агаарыг ажиглацгаая <table border="1"> <tr> <td></td> <td colspan="5">Сар өдөр</td> </tr> <tr> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Агаарын хэм</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>үүлшилт</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Салхи</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Хур тунадас</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> </table> 		Сар өдөр											Агаарын хэм						үүлшилт						Салхи						Хур тунадас					
Ангид	Гадаа																																									
	Сар өдөр																																									
Агаарын хэм																																										
үүлшилт																																										
Салхи																																										
Хур тунадас																																										

Хөтөлбөр боловсруулсан баг: Д.Амаржаргал Хөвсгөл Их-Уул сум

Д.Цэвэлсодном Баянхонгор Номгон сургууль

Н.Нямсүрэн Өвөрхангай Арвайхээр 2-р сургууль

Л.Өлзийсайхан Булган Сэлэнгэ сум

Н.Ундармаа Булган Гурванбулаг сум

А.Нармандах Булган Хутаг-Өндөр сум

Г.Батбаяр Баянхонгор БСГ

Б.Гантуяа Булган 1-р сургууль

С.Биндэрьяа 1-р сургууль

Н.Баярсайхан 1-р сургууль

Хүн орчин хичээлийн нэгж хичээлийн хөтөлбөр

Нэгж хичээлийн сэдэв: Уур амьсгал

Зорилго:

- Цаг агаар ,уур амьсгалын ялгааг мэдэх
- *Цаг агаарын байдлыг ажиглуулан амьдрал ахуйдаа зөв зохистой хэрэгжүүлж хэвшүүлэх*
 - Зорилт: Цаг агаар, уур амьсгалын онцлог ,өөрчлөлт
 - Цаг агаарын байдлыг урьдчилан мэддэг монголчуудын уламжлалт арга ухаан
 - Цаг агаар урьдчилан мэдэхийн ач холбогдол

Цагийн төлөвлөлт

1	Хичээлийн сэдэв	цаг
1	Цаг агаар	1
2	Ажиглалт туршилт	1
3	Уур амьсгал	1
4	Дүгнэлт	1